



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 5 болон 6 дахь долоо хоног



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2022 оны 02-р сарын 09-ний байдлаар

Энэ удаагийн танилцуулгад i) Олон улсын эдийн засагт өрнөж буй онцлох үйл явдлууд, ii) Түүхий эдийн зах зээлд гарсан өөрчлөлтийг тоймлон орууллаа.

Хураангуй

- Олон улсын томоохон байгууллагууд, агентлагуудын төсөөллийн дунджаар дэлхийн эдийн засаг 2022 онд 4.2 хувиар өсөх төлөвтэй байна.
- Украин, ОХУ-ын харилцаа хурцадмал байгаа нь тодорхой бус байдлыг нэмэгдүүлж глобал эдийн засагт сөргөөр нөлөөлж байна.
- Олон улсад хүнсний үнийн өсөлт саарч байгаа хэдий ч өндөр хэвээр байна.
- Хятадын эдийн засгийн өсөлтийн эрч суларч байна.
- АНУ-ын эдийн засаг 2021 онд жилийн 5.7 хувиар, Евро бүсийн эдийн засаг жилийн 5.2 хувиар өслөө. Цар тахлын тархалтын улмаас 2022 оны эхэнд АНУ, Евро бүсийн үйлчилгээний салбарын өсөлт саарав.

1

ОЛОН УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ӨРНӨЖ БУЙ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД

Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

Олон улсын томоохон байгууллагууд, агентлагууд 2022 оны 1, 2-р сард глобал эдийн засгийн өсөлтийн төсөөллийг шинэчлэн зарлалаа (Хүснэгт 1). Байгууллагуудын төсөөллийн дунджаар дэлхийн эдийн засаг энэ онд 4.2 хувиар, ирэх онд 3.5 хувиар өсөх төлөвтэй байна. Цар тахлын омикрон хувилбарын тархалт оны эхний улиралд өндөр хэвээр байх хэдий ч, улс орнуудын хол хорио харьцангуй сул байж вирусийн эдийн

засагт үзүүлэх сөрөг нөлөө нь дельта хувилбараас бага байх, нийлүүлэлтийн тасалдал /доголдол багасч, томоохон эдийн засгуудын өсөлт үргэлжлэх хүлээлттэй байна. Тухайлбал, эдийн засгийн 3 том төв болох АНУ, БНХАУ, Евро бүсийн эдийн засгууд 2022 онд урт хугацааны трендээс давж өсөх төлөвтэй боллоо. Харин хөгжиж буй орнуудын хувьд энэ онд нийтийн дархлаандаа хүрч амжихгүй тул цар тахлын сөрөг нөлөө хөгжсөн орнуудаас илүү хүндээр тусахаар байна.

Хүснэгт 1. Дэлхийн томоохон санхүүгийн байгууллага, олон улсын агентуудын 2022 оны дэлхийн эдийн засгийн өсөлтийн суурь төсөөллүүд

	Эх сурвалжууд	Төсөөлөл хийсэн огноо	Дэлхийн эдийн засгийн өсөлт	Хятадын өсөлт	АНУ-ын өсөлт	Евро бүс өсөлт	ОХУ-ын өсөлт
1	ОУВС	1/26/2022	4.4	4.8	4.0	3.9	2.8
2	Дэлхийн Банк	1/12/2022	4.1	5.1	3.7	4.2	2.4



3	НУБ	1/13/2022	4.0	5.2	3.5	4.0	2.7
4	Рубини	12/17/2021	4.2	5.5	3.9	3.9	2.2
5	Барклийс	2/4/2022	4.2	4.7	3.7	4.1	2.6
6	Коммерзбанк	2/4/2022	4.5	4.5	3.8	3.5	-
7	Фитч	2/7/2022	-	4.8	3.7	3.9	2.6
	Дундаж		4.2	4.9	3.8	3.9	2.6

Эх сурвалж: Төсөөлөл хийсэн байгууллагуудын цахим хуудсууд

АНУ-ын эдийн засагт болсон голлох өөрчлөлт

АНУ-ын эдийн засаг 2021 онд жилийн 5.7 хувиар өслөө. Тус эдийн засаг 2021 оны 3-р улиралд өмнөх улирлаас жилд шилжүүлсэн хувиар¹ 2.3 хувиар өссөн бол 4-р улиралд 6.9 хувиар өсөж огцом тэллээ. Энэ томоохон өсөлт (6.9 хувь)-ийн дийлэнх буюу 4.9 хувийг материаллаг хөрөнгийн эргэлтийн өсөлт бий болгожээ. Тухайлбал, бөөний болон жижиглэн худалдааны салбар, автомашины компаниуд эрэлт өндөр байгаа үед бараа материалын дутагдалд орохоос сэргийлж их хэмжээгээр нөөц, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлсэн нь үүнд нөлөөлсөн байна. Харин материаллаг хөрөнгийн өөрчлөлт 2022 оны эхний улиралд төдийлөн өсөхөөргүй байгаа тул эдийн засгийн өсөлтийг бууруулах нөлөө үзүүлэх төлөвтэй. АНУ-ын ДНБ-ий гол бүрэлдэхүүн болох хувийн хэрэглээ өмнөх оны 4-р улиралд жилийн 3.3 хувиар өсжээ. Үүнд, барааны эрэлт суларч, барааны хэрэглээ 0.5 хувиар өссөн бол үйлчилгээ үргэлжлэн сэргэж, үйлчилгээний хэрэглээ 4.7 хувиар өссөн дүр зурагтай байна. Тайлант улиралд бизнесийн хөрөнгө оруулалт (мэдээллийн технологи, оюуны өмч) 10.6 хувиар өсөж хурдтай сэргэсэн бол машин, тоног төхөөрөмжийн хөрөнгө

оруулалт дөнгөж 0.8 хувиар өсжээ. Харин үл хөдлөх салбарын хөрөнгө оруулалт 0.8 хувиар буурсан байна. Цэвэр экспортыг авч үзвэл тус улсын барааны экспорт 24.4 хувиар, үйлчилгээний экспорт 24.7 хувиар өссөн бол бараа, үйлчилгээний импорт аль аль нь 17.7 хувиар өслөө.

Хэдийгээр АНУ-ын эдийн засаг өссөн ч иргэдийн зарцуулагдаагүй бодит орлого тайлант улиралд 5.8 хувиар буурчээ. Цалингийн орлого өссөн боловч Засгийн газрын дэмжлэг, хөтөлбөрүүд (ялангуяа хүүхдэд олгож байсан мөнгөн тусламж 12-р сараас) зогссон нь хувийн орлого буурахад нөлөөлөв. Мөн Засгийн газраас өргөн бариад буй багц² (хүүхдийн мөнгийг үргэлжлүүлэн олгохоор тусгасан) батлагдахгүй тохиолдолд өрхийн орлого ирэх улирлуудад буурахаар байна.

Энэ оны эхний сард Омикрон хувилбарын тархалт огцом нэмэгдэж, АНУ-ын борлуулалтын менежерүүдийн индекс сүүлийн 18 сарын хамгийн бага түвшинд хүрлээ. Үйлчилгээний салбарын борлуулалтын менежерүүдийн индекс өнгөрсөн оны 12-р сард 57.6 байсан бол энэ оны 1-р сард 50.9 болж өсөлт огцом буурав. Ажиллах хүчний хомстол нь үйлчилгээний салбарын тэлэлтэд гол

¹ Annualized quarter-on-quarter growth.

² Build Back Better Bill



хязгаарлалт болж байна. Мөн боловсруулах салбарын борлуулалтын менежерүүдийн индекс 12-р сард 57.7 байсан бол энэ оны 1-р сард 55.0 болж саарчээ.

АНУ-ын ХНБ 2022 оны 1-р сарын 25-26-ны өдрийн хурлаараа Төв банкны хөрөнгө худалдан авалтаа үргэлжлүүлэн бууруулж, энэ оны 3-р сар гэхэд худалдан авалтыг дуусгах, ХНБ-ны хүүгээ хэвээр хадгалахаар шийдвэрлэв. Мөн Төв банк “ХНБ-ны хүүг өөрчлөхөд тохиромжтой хугацаа дөхөж байгаа”-г мэдэгдлээ. ХНБ-ны мэдэгдэлд санхүүгийн нөхцөл сул байгаа тул хүү өсгөх шийдвэрүүд нь хөдөлмөрийн захад сөрөг нөлөө үзүүлэхгүй болохыг онцолсон байна. Улмаар Төв банкны сүүлийн мэдэгдэлд үндэслэн, шинжээчид ХНБ 3-р сарын хурлаараа бодлогын хүүгээ өсгөх, мөн энэ онд бодлогын хүүг нийтдээ 4-5 удаа өсгөхөөр хүлээж байна. Иймд ХНБ-ны хүү оны эцэст 1-1.5 хооронд хүрч өсөх төлөвтэй боллоо.

Евро бүсийн эдийн засагт болсон голлох өөрчлөлт

Евро бүсийн 2021 оны 4-р улирлын эдийн засгийн урьдчилсан гүйцэтгэл зарлагдлаа. Бүсийн томоохон эдийн засгуудын хувьд өсөлтийн гүйцэтгэл харилцан адилгүй байв. Тухайлбал, тайлант улиралд Германы эдийн засаг агшиж, Францын эдийн засгийн өсөлт саарч, Испанийн эдийн засаг хэвийн өсөлттэй гарав.

- Германы эдийн засаг цар тахлаас сэргийлэх хөл хорио тогтоосны улмаас 2021 оны 4-р улиралд өмнөх улирлаас 0.7 хувиар буурсан бөгөөд жилийн нийт дүнгээр 2021 онд харьцангуй сул буюу 2.8 хувиар өсжээ. Энэ оны эхний улиралд цар тахлын тархалт төдийлөн буурахааргүй тул өсөлт сул байх

төлөвтэй байна. Германы Засгийн газар эдийн засгаа 2022 онд 3.6 хувиар өсөхөөр төсөөлжээ. Түүнчлэн, тус улс нийлүүлэлтийн гинжин сүлжээний доголдоос шалтгаалан экспортын эрэлтийг хангаж чадахгүй байгаагаас инфляц өндөр түвшинд хүрч, эдийн засгийн өсөлт нь хязгаарлагдсан төвөгтэй нөхцөл байдалд ороод байна. Цаашид Европын төв банк бүс нутгийн инфляцын зорилтыг хангах хүрээнд мөнгөний бодлогын төлөвөө чангаруулах тохиолдолд энэ нь Германд үүсээд буй нийлүүлэлтийн шалтгаантай инфляцыг төдийлөн шийдвэрлэж чадахгүй боловч эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж болзошгүй байна.

- Францын эдийн засаг 4-р улиралд өмнөх улирлаас 0.7 хувиар өсөв. Энэ нь өмнөх улирлын 3.1 хувийн өсөлттэй харьцуулахад өсөлт огцом саарсан дүр зураг юм. Ийнхүү өсөлт саарахад хувийн хэрэглээ удааширсан нь голлон нөлөөллөө. Харин бизнесийн хөрөнгө оруулалт өсөлтийг тэтгэх нөлөөтэй байв. Жилийн нийлбэр дүнгээр авч үзвэл 2021 онд Францын эдийн засаг жилийн 7 хувиар өсөөд байгаа нь сүүлийн 52 жилийн хамгийн өндөр өсөлт болжээ.
- Испанийн эдийн засаг 3-р улиралд өмнөх улирлаас 2.6 хувиар өссөн бол 4-р улиралд өмнөх улирлаас 2 хувиар өслөө. Тайлант улиралд бизнесийн хөрөнгө оруулалт эрчимжсэн (бизнесийн тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт 6.1 хувиар өссөн, оюуны өмчийн хөрөнгө оруулалт 10 хувиар өссөн) нь өсөлтийг тэтгэх гол хүчин зүйл болов. Харин цар тахлын тархалт, өндөр инфляцын нөлөөгөөр хувийн хэрэглээ агшсан байна.
- Евро бүсийн **боловсруулах салбарын** борлуулалтын менежерүүдийн индекс энэ оны 1-р сард өссөн бол **үйлчилгээний салбарын** борлуулалтын менежерүүдийн индексийн өсөлт саарлаа. Тодруулбал, үйлчилгээний салбарын борлуулалтын менежерүүдийн индекс 12-р сард 53.1



байсан бол энэ оны 1-р сард 51.2 болж өсөлт нь саарсан байна. Улс орнууд хөл хориогоо чангатгасан, иргэдийн болгоомжлол нэмэгдсэний улмаас зочид буудал, рестораны үйлчилгээний эрэлт буурчээ. Харин боловсруулах салбарын борлуулалтын менежерүүдийн индекс


12-р сард 53.8 байсан бол энэ оны 1-р сард 55.8 болж өссөн байна. Үүнд аж үйлдвэрийн салбар дахь ажиллах хүчин дутагдалтай байгаа ч нийлүүлэлтийн доголдол багасах төлөвтэй болж, Германы автомашины үйлдвэрлэл сэргэж эхэлсэн нь голлон нөлөөлжээ.

Олон улсын зах зээл дээрх хүнсний үнэ


НҮБ-ын Хүнс хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг “Олон улсын хүнсний үнийн индекс³” 2022 оны 1 сард 135.7-д хүрч өмнөх оны мөн үеэс **19.5 хувиар** өслөө (Зураг 1). Энэ хугацаанд

элсэн чихрээс бусад дийлэнх хүнсний бүтээгдэхүүний үнэ өссөн нь нийт хүнсний үнийн индекс өсөхөд гол нөлөө үзүүлжээ (Зураг 2).

Зураг 1. Олон улсын хүнсний үнийн индекс



Зураг 2. Зарим бүтээгдэхүүний жилийн инфляц



Эх сурвалж: НҮБ-ийн Хүнс хөдөө аж ахуйн байгууллага

Хүнсний инфляцын дэд бүлгүүдийн үнийн өөрчлөлтийг тус бүрд нь доор авч үзье.

Үр тарианы үнэ. 2022 оны 1-р сард улирлын онцлогоороо Австрали, Аргентины **улаан буудайн** ургац хураалт нэмэгдэж, үүний зэрэгцээ эрэлт саарсан нь оны эхний сард үр тарианы үнэ буурах шалтгаан болсон байна. Харин улаан буудайн эрэлт өндөр хэвээр байж, сайн чанарын улаан буудайн

нийлүүлэлт төдийлөн нэмэгдээгүй нь үнэ илүү хурдтай буурах боломжийг хязгаарлалаа. Бразил, Аргентинд үргэлжилж буй ган, эрдэнэ шишийн эрэлт өндөр байгаа зэрэг нь **эрдэнэ шишийн** үнэ өндөр хэвээр хадгалагдахад нөлөөлөв. Эрдэнэ шишийн зах зээлийн нөлөөгөөр **Соргумын**⁴ үнэ ч мөн өссөн байна. Азийн гол худалдан авагчдын **будааны** эрэлт өссөн, ургац хураалтын үе дууссан

³ Мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тариа, тос, тосон бүтээгдэхүүн, элсэн чихэр зэрэг бүтээгдэхүүнээс бүрддэг

⁴ Sorghum



зэргээс шалтгаалан будааны үнэ 2022 оны 1-р сард 3.1 хувиар өсөв.

Тос, тосон бүтээгдэхүүний үнэ. Тос, тосон бүтээгдэхүүний үнэ 2022 оны 1-р сард өмнөх оны мөн үеэс 33.9 хувиар өсөв. Дал модны тос, наранцэцгийн тос, шар буурцгийн тос, рапсын үнэ 1-р сард бүгд өслөө. Индонези улс дал модны тосны экспортоо багасгаж болзошгүй болгоомжлол бий болсон, бусад голлох экспортлогчдын үйлдвэрлэл багассан нөлөөгөөр дал модны тосны үнэ өсөв. Мөн шар буурцгийн импортын эрэлт, ялангуяа Энэтхэгийн эрэлт, нэмэгдэж үнэ нь өслөө. Рапс, наранцэцгийн тосны хувьд импортын эрэлт өсөж, нийлүүлэлт бага байсан нь үнэ өсөхөд нөлөөлөв. Түүнчлэн дэлхийн зах зээл дээрх газрын тосны үнэ өсч байгаа нь тос, тосон бүтээгдэхүүний үнийг өдөөж байна.

Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ (хуурай сүү, бяслаг, цөцгийн тос, өрөм). Сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 2022 оны 1-р сард өмнөх сараас 2.4 хувиар өссөн буюу 5 дахь сардаа дараалан өсөв. Дэлхийн сүүний экспорт, ялангуяа Баруун Европын орнуудын сүүний үйлдвэрлэл, нөөц буурсан нь дэлхий нийтийн сүүний нийлүүлэлтийг бууруулж, сүүний үнэ өсөхөд нөлөөлөв. Мөн далайн орнуудын сүүний үйлдвэрлэл ойрын саруудад нэмэгдэхээргүй байгаа нь дэлхийн сүү, сүүн бүтээгдэхүүний зах зээл дээрх үнэ

ойрын хугацаанд өндөр хэвээр хадгалагдахад нөлөөлөхөөр байна.

Махны үнэ (үхэр, хонь, шувуу, гахай). Махны үнэ 2022 оны 1-р сард өмнөх сараас бага зэрэг өсөж, өмнөх оны мөн үеэс 17.3 хувиар өндөр байв. Үнэ өсөхөд дэлхийн зах зээл дээрх үхрийн махны импортын эрэлт өсч, нийлүүлэлт хангалтгүй байсан нь голлон нөлөөлөв. Нийлүүлэлтийн талаас ялангуяа Бразил болон далайн орнуудын нядалгааны малын тоо толгой бага байж, үйлдвэрлэл хязгаарлагдмал байв. Харин Хятадын гахайн махны импортын эрэлт саарсан хэдий ч нөгөө талаас ажиллах хүчин хомс байж, үйлдвэрлэлийн орцын зардал нэмэгдсэн нөлөөгөөр дотоодын нийлүүлэлт буурч, гахайн махны үнэ ялимгүй өслөө. Шувууны махны хувьд экспортлох боломжтой хэмжээ өссөн тул үнэ нь буурав.

Элсэн чихрийн үнэ. Элсэн чихрийн үнэ 2022 оны 1-р сард өмнөх сараас 3.1 хувиар буурчээ. Үүнд голлох экспортлогч орнууд болох Энэтхэг, Тайландын ургац хураалт сайн байж, Бразилын гол тариалангийн бүсэд хур тунадас нэмэгдсэнээр элсэн чихрийн үйлдвэрлэл нэмэгдэх нааштай төлөвтэй болсон тул үнэ ийнхүү хямдрал. Мөн Бразилд этанолын үнэ буурч, дэлхийн зах зээлийн элсэн чихрийн үнийг бууруулахад нөлөөлөв.


2

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ БОЛСОН ГОЛЛОХ ӨӨРЧЛӨЛТ


- Хятадын эдийн засгийн идэвхжлийг илтгэх борлуулалтын менежерүүдийн нийлмэл индекс 2022 оны 1-р сард 51-д хүрч өмнөх сараас 1.2 нэгжээр багассан нь Хятадын эдийн засаг өсөх чиглэлд хөдөлж байгаа ч эдийн засгийн идэвхжил саарч байгааг илтгэж байна.
- Хятадын боловсруулах салбарын борлуулалтын менежерүүдийн индекс 2022 оны 1-р сард 50.1 болж өмнөх

сараас 0.2-оор буурч, боловсруулах салбарын өсөлт удааширч байна /Зураг 1/. Аж ахуй нэгжийн хэмжээгээр авч үзвэл томоохон аж ахуй нэгжүүдийн хувьд энэхүү индекс нь 51.6 буюу өмнөх сараас 0.3-аар өссөн бол дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн хувьд 50.5-д хүрч өмнөх сараас 0.8-аар, жижиг хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн хувьд 46-д хүрч 0.5-аар тус тус буураад байна.

Зураг 1. Хятадын аж үйлдвэрийн салбарын борлуулалтын менежерүүдийн индекс, улирлын зохицуулалттай



Зураг 2. Хятадын аж үйлдвэрээс бусад салбарын борлуулалтын менежерүүдийн индекс, улирлын зохицуулалттай



Эх сурвалж: Хятадын Үндэсний статистикийн газар

- Боловсруулахаас бусад салбарын борлуулалтын менежерүүдийн индекс 2022 оны 1-р сард 51.1 буюу өмнөх сараас 1.6 нэгжээр буурчээ. Энэ нь Хятадын боловсруулахаас бусад

салбарын өсөлт ч мөн удааширч байгааг илтгэж байна /Зураг 2/. Салбараар авч үзвэл барилга өмнөх сараас 0.9 нэгжээр агшиж 55.4, үйлчилгээ өмнөх сараас 1.7 нэгжээр буурч 50.3 хүрэв.

3 ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

Коксжих нүүрсний зах зээл

- Үнэ:** Хятадын мужуудад коксжих нүүрсний үнэ тогтвортой байсан бол боомтуудын үнэ нэмэгдлээ. Тухайлбал, 2022 оны 1-р сарын 30-ны байдлаар Хэбэй мужид коксжих нүүрсний үнэ өмнөх хоёр долоо хоногоос өөрчлөлтгүй 3,160 юань (498\$), Шаньси мужид мөн үнэ төдийлөн өөрчлөгдөөгүй 2,960 юань (467\$)-д хадгалагдав. Харин Таньжин боомтод коксжих нүүрсний үнэ өмнөх хоёр долоо хоногоос 120 юаниар нэмэгдэж 3,050 юань (480\$)-д хүрээд байна.
- Эрэлт:** Томоохон хэрэглэгчид нүүрсний нөөцөө ихээхэн хэмжээнд бүрдүүлсэн, Хятадын өвлийн олимп 2-р сарын 4-20-ны хооронд зохион байгуулагдаж байгаатай холбоотойгоор гангийн үйлдвэрлэлд хязгаарлалт тогтоосон зэргээс шалтгаалж коксжих нүүрсний эрэлт бага байна.

- Нийлүүлэлт:** Коксжих нүүрсний нийлүүлэлт өмнөх хоёр долоо хоногоос буурав. Тухайлбал, Хятадын цагаан сар, Олимптой холбоотойгоор нүүрсний үйлдвэрлэлийг хязгаарлаад байна. Хэбэй мужийн нүүрсний ордууд үйлдвэрлэлээ 40 хувиар танасан бол Шаньси, Шандон мужуудын үйлдвэрүүд 30-50 хувийн хүчин чадлаар ажиллав. Шандон мужид нүүрсний үйлдвэрлэлийг гангийн үйлдвэрээс илүүтэй хязгаарлав. SXcoal судалгааны байгууллагын судалгаанд хамрагдсан нүүрсний үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалт энэ оны 1-р сарын 28-ны байдлаар өмнөх 2 долоо хоногоос 6.0 нэгж хувиар буурч 92 хувьд хүрээд байна.
- Нөөц:** Цасархаг цаг агаарын улмаас нүүрс тээвэрлэхэд хүндрэлтэй болж нүүрсний үйлдвэрүүдийн нүүрсний нөөц нэмэгдээд байна. Тухайлбал, Хятадын хувьд SXcoal судалгааны



байгууллагын судалгаанд хамрагдсан үйлдвэрүүдийн нөөц 2022 оны 1-р сарын 28-ны байдлаар өмнөх 2 долоо хоногоос 240 мянган тонноор нэмэгдэж 1.4 сая тоннд хүрэв.

- **Цаашдын хүлээлт:** Хятадын өвлийн олимп тээвэр, логистикт хүндрэл учруулна гэж үзэн, гангийн үйлдвэрүүд нүүрсний нөөцөө өмнөх 7 хоногуудад нэмэгдүүлсэн байна. Нөгөөтгээгүүр, коксжих нүүрсний үйлдвэрүүд олборлолтоо нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал тул нүүрсний үнэ өсөх хүлээлттэй байна.

Монголын нүүрсний экспорт

- Цаг агаарын таагүй байдал, цар тахлын тархалтаас шалтгаалж Хятадын зүгээс импортын нүүрсийг тээвэрлэхэд хүндрэлтэй байлаа. Улмаар Гашуунсухайт-Ганцмод боомтоор нэвтэрсэн ачааны машины дундаж тоо бага хэвээр үргэлжлэв. Харин боомтоор нэвтэрсэн нүүрсний үнэ өмнөх 2 долоо хоногоос тонн тутамд 70 юаниар нэмэгдэж 2,060 юанд (324\$) хүрэв.
- Шивээхүрэн-Сэхэ боомт хаалттай хэвээр байгаа бөгөөд тус боомт дээрх коксжих нүүрсний үнэ өмнөх 7 хоногоос өөрчлөлтгүй, 1,550 юань (\$243) хэвээр байна.

Экспортын голлох түүхий эдийн дэлхийн зах зээл дээрх үнийн өөрчлөлт

/2022 оны 2-р сарын 10-ны байдлаар/

Бодит гүйцэтгэл						
	Үнэ	Өөрчлөлт				Товч тайлбар
	(-1 day) 2020/10/16	daily	weekly	monthly	year to date	
Зэс	10,254	1.9	4.3	7.2	23.5	Нэг тонн зэсийн үнэ 2-р сарын 10-ны байдлаар 10,254 ам.долларт хүрч өсөөд байна. АНУ-ын инфляц хүлээлтээс давж өсөж 7.5 хүрсэн нь зах зээлд оролцогчдын ам.долларын эрэлтийг бууруулж, голлох металлуудын эрэлтийг нэмэгдүүлээд байна. Түүнчлэн Лондонгийн металлын бирж, Шанхайн бирж, CME зэрэг дэлхийн томоохон биржүүдэд зэсийн нөөц 1-р сарын эцэст 200.4 мянган тоннд хүрч 4 дэх жилдээ дараалан буураад байгаа нь зэсийн үнэ ийнхүү өсөхөд голлох нөлөөг үзүүлэв.
Төмрийн хүдэр	152	2.7	3.9	21.8	-5.1	Нэг тонн төмрийн хүдрийн үнэ 152 болж нэмэгдлээ. Хятадын зүгээс гангийн үйлдвэрлэлийн хувьд нүүрсхүчлийн хийн ялгарлыг бууруулах төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулж, зорилгот оныг 2025 байсанг 2030 болгосноо 2-р сарын 8-ны өдөр мэдэгдээд байна. Энэхүү мэдэгдэл нь гангийн үйлдвэрлэлийн гол түүхий эд болох төмрийн хүдрийн үнэд эерэгээр нөлөөллөө.
Алт	1,827	-0.4	1.2	1.4	-0.9	Нэг унц алтны үнэ 2-р сарын 10-ны байдлаар 1,827 долларт хүрэв. Нэг талаас АНУ-ын инфляц сүүлийн 40 жилийн хамгийн дээд цэгт хүрсэн нь алтны эрэлтийг нэмэгдүүлж байгаа ч зах зээлд оролцогчдын дунд ХНБ-наас хүүгээ өсгөх хүлээлттэй байгаа тул алтны үнэ харьцангуй багаар өсөөд байна.
Газрын тос (Брент)	91	-0.2	0.3	13.0	48.7	Газрын тосны үнэ 2022 он гарсаар өсөх трендтэй байна. Брент маркын нэг баррель газрын тосны үнэ 2022 оны 2-р сарын 4-ний өдрийн байдлаар 93.3 ам.долларт 2014 оны 10-р сараас хойш хамгийн өндөр утгад хүрэв. Харин 2-р сарын 10-ны өдрийн байдлаар нэг баррель газрын тосны үнэ 91 ам.доллар байна. АНУ-ын хөдөлмөрийн зах зээлийн үзүүлэлтүүд эерэг гарч, зах зээлд оролцогчид газрын тосны нийлүүлэлт эрэлтээ хангаж чадахааргүй байгаа гэж хүлээж байгаагаас газрын тосны үнэ ийнхүү нэмэгдээд байна. Түүнчлэн, Орос Украины дайн үүсэх эрсдэл нь нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсгэсэн, байгалийн хийн үнэ өмнөх оноос огцом нэмэгдээд байгаа нь байгалийн хийг газрын тосоор орлуулах хэрэглээг нэмэгдүүлж газрын тосны эрэлтийг улам нэмэгдүүлж байна. Нийлүүлэлт талаас 2022 оны 2-р сарын 2-ны өдөр ОПЕК+ хуралдаж үйлдвэрлэлийн төлөвлөгөөндөө өөрчлөлт оруулахгүй гэж мэдэгдлээ. Цаашид Орос Украины хооронд дайн үүсвэл газрын тосны үнэ цаашид 100 ам.доллар давах эрсдэлтэй талаар "Reuters" агентлагаас мэдээлээд байна.

Брент маркын нэг баррель газрын тосны үнэ



Эх сурвалж: Блүүмберг

Ашигласан материалууд:

1. *SX Coal, Weekly Update, January 29th, 2022*
2. *World Bank, Global Economic Prospects, February 7th, 2022*
3. http://www.stats.gov.cn/english/PressRelease/202202/t20220207_1827228.html#:~:text=Purchasing%20Managers%20Index%20for%20January%202022&text=In%20January%20C%20the%20Purchasing%20Manager,of%20manufacturing%20expansion%20slowed%20down.
4. <https://blinks.bloomberg.com/news/stories/R73R36T1UM14>
5. <https://blinks.bloomberg.com/news/stories/R74E19T0AFB4>
6. <https://continuumeconomics.com/2021/12/20/outlook-overview/charting-our-views-december-2021>
7. <https://continuumeconomics.com/2022/02/01/emerging-markets/ukraine-war-impact-russia-the-west-and-em>
8. <https://thedocs.worldbank.org/en/doc/a8b46c2ac87710fa9694cb6ae1a891fa-0350012022/original/Global-Monthly-Jan22.pdf>
9. <https://www.fao.org/worldfoodsituation/foodpricesindex/en/>
10. <https://www.federalreserve.gov/monetarypolicy/files/monetary20220126a1.pdf>
11. <https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2022/01/25/world-economic-outlook-update-january-2022>
12. <https://www.mining.com/iron-ore-price-rise-to-150-after-beijing-eases-steels-green-targets/>
13. https://www.opec.org/opec_web/en/press_room/6796.htm
14. <https://www.reuters.com/business/energy/oil-extends-gains-above-90bbl-winter-storm-sweeps-through-united-states-2022-02-04/>
15. <https://www.reuters.com/business/new-lme-stocks-squeeze-is-creeping-up-doctor-copper-andy-home-2022-02-08/>
16. https://www.un.org/development/desa/dpad/wp-content/uploads/sites/45/publication/WESP2022_web.pdf
17. <https://www2.deloitte.com/us/en/insights/economy/global-economic-outlook/weekly-update.html>